



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/149

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам батлах тухай” 2020 оны А/120 дугаар тушаалын 3.14 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, аймгийн “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг тус тус боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Хулан (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Гишүүд:

С.Цэнгэлмаа (Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Н.Сүхбаатар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Э.Одончимэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Энхтуяа (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Хоёр. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030” болон бусад төрийн бодлого, хууль тогтоомжуудтай уялдуулан, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн саналыг тусган аймгийн “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, аймгийн “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж батлуулахыг ажлын хэсэг (С.Хулан)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060644